

2018 ОНЫ ӨРГӨДЛИЙН СУДАЛГАА

**ХЯНАЛТ ШАЛГАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗАР**

Улаанбаатар хот
2018 он

АГУУЛГА

1. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА.....2

САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

1.1.	Үнэт цаасны зах зээл.....	3
1.2.	Даатгалын салбар.....	5
1.3.	Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)	7
1.4.	Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ).....	8

2. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ8

ХҮСНЭГТҮҮД:

Хүснэгт 1.	Өргөдлийн тоо (улирлаар).....	2
Хүснэгт 2.	Өргөдөл, гомдлын утга	2
Хүснэгт 3.	Өргөдөлд хамаарах санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл.....	3
Хүснэгт 4.	Үнэт цаасны зах зээлтэй холбоотой ирсэн өргөдлийн товч утга	3
Хүснэгт 5.	Үнэт цаасны зах зээлтэй холбоотой өргөдлийн шийдвэрлэлт	4
Хүснэгт 6.	Даатгалтай холбоотой ирсэн өргөдлийн утга, ангилал	5
Хүснэгт 7.	Даатгалын бүтээгдэхүүний төрөл.....	5
Хүснэгт 8.	Даатгалтай холбоотой өргөдлийн шийдвэрлэлт	6
Хүснэгт 9.	Урьдчилан шийдвэрлэгдсэн нөхөн төлбөрийн дүн	6
Хүснэгт 10.	ББСБ-тай холбоотой өргөдлийн товч утга.....	7
Хүснэгт 11.	ББСБ-тай холбоотой өргөдөл, гомдлын шийдвэрлэлт.....	7
Хүснэгт 12.	ХЗХ-ны үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн товч утга.....	8

ДҮРСЛЭЛ:

Дүрслэл 1.	Өргөдлийг шийдвэрлэсэн дундаж хугацаа (хоногоор)	8
------------	--	---

1. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газар нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянаж, санал дүгнэлт гарган хуульд заасан эрх хэмжээний хүрээнд урьдчилан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Хяналт шалгалт, зохицуулалтын газарт хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс 2018 онд өссөн дүнгээр нийт 322 өргөдөл ирсэн байна.

Хүснэгт 1. Өргөдлийн тоо (улирлаар)

№	Салбар	2017.1	2017.2	2017.3	2017.4	2018.1	2018.2	2018.3	2018.4
1	Даатгал	42	23	29	45	40	38	25	47
2	Үнэт цаас	23	12	12	20	28	29	21	30
3	ББСБ	10	7	6	10	18	11	11	12
4	ХЗХ	8	5	1	5	4	2	0	2
5	Бусад	3	2	1	3	2	0	0	2
	Нийт	86	49	49	83	92	80	57	93

Тус Хороонд 2018 онд ирүүлсэн нийт өргөдлийн тоог өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад 20.6 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Өргөдлийн тоо үнэт цаасны зах зээл дахь үйл ажиллагаатай холбоотойгоор 61.2, ББСБ 57.6, даатгалын салбарын хувьд 8.9 хувиар тус тус өссөн бол ХЗХ-дын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо 57.9 хувиар буурчээ.

1.1 Өргөдөл, гомдлын утга болон бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тус Хороо санхүүгийн хэрэглэгчийн хууль ёсны эрх ашиг зөрчигдсөн асуудлаар нийт 322 өргөдөл, гомдол ирсэн байна. Өргөдөл, гомдлын харьцуулсан судалгааг голлох утгаар нь¹ ангилж, хүснэгтлэн харуулав:

Хүснэгт 2. Өргөдөл, гомдлын утга

Д/д	Өргөдөл, гомдлын утга	2017/4	2018/4
1	Даатгалын нөхөн төлбөр	133	142
2	Хувьцааны өмчлөл	34	56
3	Үнэт цаасны бүртгэл	28	36
4	Зээлийн гэрээний маргаан*	27	16
5	Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа	10	16
6	Үнэт цаасны зах зээлд оролцогчдын үйл ажиллагаа	4	16
7	Зээлийн мэдээллийн сан	7	13
8	Даатгалын үйлчилгээтэй холбоотой бусад	7	8
9	Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа	9	6
10	Бусад (ломбард, иргэд хоорондын гэрээний маргаан, сүлжээний бизнес гэх мэт)	8	13
	Нийт	267	322

¹Санхүүгийн хэрэглэгчийн зүгээс Хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлыг утгаар нь багцлав.

*Банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж, зээлийн хоршооны зээлийн маргааныг хамтад нь оруулав.

Тайлант хугацаанд Хороонд ирсэн өргөдөл, гомдлыг бүтээгдэхүүн, үйлчилгээгээр² нь бүлэглэн дор харуулав.

Хүснэгт 3. Өргөдөл хамаарах санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл

Д/д	Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл	2017/4	2018/4
1	Тээврийн хэрэгслийн даатгал	36	65
2	Зээлийн гэрээ, хүү, барьцаа хөрөнгө	46	38
3	Харилцагчийн данс	3	37
4	Хөрөнгө оруулалтын эрхийн бичиг	8	36
5	Бусад даатгал	20	31
6	Өмчлөгчийн зөвшөөрөлгүй зарагдсан хувьцаа	51	30
7	Жолоочийн хариуцлагын даатгал	47	24
8	Орон сууцны зээлдэгчийн эрсдэлийн даатгал	32	22
9	Зээлийн ангилал	7	13
10	Даатгалын хохирлын үнэлгээ, даатгалын хураамж	4	8
11	Хувьцаат компанийн ногдол ашиг	4	5
12	Бусад (лавлагаа, тодорхойлолт, иргэд хоорондын гэрээний маргаан, сүлжээний бизнес гэх мэт)	9	13
Нийт		267	322

1.2 Салбарын үзүүлэлтүүд

Тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдын хоорондын маргааныг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 33 дугаар зүйлийн 33.1, Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.1-д тус тус заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд санхүүгийн зах зээл дээр үйл ажиллагаа эрхэлж буй үнэт цаас, даатгал, банк санхүүгийн байгууллагын үйлчлүүлэгч, хадгаламж, зээлийн хоршооны гишүүд болон иргэдээс Хороонд хандаж, 2018 онд ирүүлсэн өргөдөл, гомдлын талаарх мэдээллийг дор сийрүүлэв.

1.2.1 Үнэт цаасны зах зээл

Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээлийн байгууллагуудтай холбоотой нийт 108 өргөдөл ирснээс 106 нь хуулийн хугацаанд хянан шийдвэрлэгдэж, 2 өргөдөл хянагдах шатанд байна.

Хүснэгт 4. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой өргөдлийн товч утга

Д/д	Товч утга	2017/ 4 тоо	Эзлэх хувь	2018/4 тоо	Эзлэх хувь
1	Хувьцааны бүртгэл, дансны мэдээлэл шалгуулах	8	12.1%	36	33.3%
2	Хувьцаа зөвшөөрөлгүй арилжаалсан	51	77.3%	30	27.8%

²Санхүүгийн хэрэглэгчийн зүгээс Хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлыг бүтээгдэхүүн, үйлчилгээг төрлөөр нь багцлав.

3	ҮЦК, ХК-ийн үйл ажиллагаа	3	4.5%	14	12.9%
4	Ногдол ашиг	1	1.5%	5	4.6%
5	Хувьцаа эзэмшигчийн нэр зөрсөн	-	-	4	3.8%
6	Хөрөнгө оруулалтын сан	-	-	3	2.8%
7	Лавлагаа гаргуулах	-	-	2	1.8%
8	Хувьцааны тоо өөрчлөгдсөн	-	-	2	1.8%
9	Данс нээлгэх тухай	1	1.5%	2	1.8%
10	Хувьцааг шилжүүлэх, шилжүүлэн авах	-	-	1	1.0%
11	Хорооноос өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй	1	1.5%	1	1.0%
12	Бусад	2	3.0%	8	7.5%
	Нийт	66	100.0%	108	100.0%

Нийт өргөдлийн 27.8 хувийг брокер, дилерийн компаниар дамжуулан эзэмшигчийн зөвшөөрөлгүй арилжаалагдсан хувьцаатай холбоотой өргөдөл эзэлсэн бөгөөд үүнээс 30.0 гаруй хувийг өмнө нь Хорооноос үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон нэр бүхий 7 брокер, дилерийн компаниар дамжуулан арилжаалагджээ. Дээр дурдсан утга бүхий өргөдлийн тоог өмнөх оны мөн улиралтай харьцуулахад 41.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Тус Хороонд үнэт цаасны зах зээлийн байгууллагуудтай холбоотой ирүүлсэн өргөдлийг дараах байдлаар урьдчилан шийдвэрлэжээ.

Хүснэгт 5. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой өргөдлийн шийдвэрлэлт

Д/д	Өргөдлийг шийдвэрлэсэн товч утга	2018/III
1	Албан бичгээр холбогдох хариуг өгч шийдвэрлэсэн	57
2	Хууль, хяналтын байгууллагад хандсан	31
3	Хорооноос үүрэг, даалгавар хүргүүлсэн	12
4	Хуулийн хугацаанд хянагдаж байгаа	8
	Нийт	108

Хувьцааг зөвшөөрөлгүй арилжаалсан үйлдэл нь Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 11.10 дугаар зүйлийн 2.20 дахь хэсгийг зөрчсөн үйлдэлд хамаарах учир Зөрчил, шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу зөрчлийн хэрэг бүртгэлийг явуулан прокурорын байгууллагаар хянуулдаг ба “Монголын хөрөнгийн бирж” ХК, “ҮЦТХТ” ХХК, үнэт цаасны компани болон шаардлагатай тохиолдолд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн болон оролцогч талуудаас тайлбар, нотлох баримтыг гаргуулсны үндсэн дээр урьдчилан шийдвэрлэдэг.

Тайлант хугацаанд дээрх тохиолдлоор ирүүлсэн 80.0 гаруй хувийн өргөдөлд хувьцаа худалдах захиалгын гэрээ болон бэлэн мөнгө хүссэн өргөдөлд нэр бүхий гарын үсэг зурагдсан бол тухайн гарын үсгийг хуурамч болохыг эрх бүхий байгууллагаар тогтоолгох, мөн 2000 оноос өмнө тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон брокер, дилерийн компаниар дамжуулан арилжаалагдсан тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 11.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.20 дахь заалтыг буцаан хэрэглэх боломжгүй, өргөдөлд дурдсан асуудал нь тухайн үеийн хуулиар зөрчилд тооцогдоогүй байсан, зөрчлийн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн зэрэг шалтгааны улмаас зөрчлийн шинжгүй гэж үзэн гомдлыг

хүлээн авахаас татгалзаж, уг асуудлаар холбогдох шүүх, хяналтын байгууллагад хандахаар урьдчилан шийдвэрлэжээ.

Тус Хорооноос өгсөн үүрэг, даалгавар түүний биелэлтийн тухайд, “Улаанбаатар хивс” ХК, “Тахь ко” ХК, “Материал импекс” ХК, “АПУ” ХК, “Дархан нэхий” ХК зэрэг компаниудын хувьцааг харилцагчийн дансанд буцаан байршуулах, “АПУ” ХК, “Дархан нэхий” ХК-ийн 2005 оноос хойших хугацааны ногдол ашгийг тооцон харилцагчдад олгуулах зэрэг 5 удаагийн хугацаатай үүрэг, даалгаврыг холбогдох үнэт цаасны компанид хүргүүлсэн бол хувьцаа эзэмшигчийн харилцагчийн дансанд "АПУ" ХК-ийн 40.000 ширхэг хувьцааг буцаан байршуулсан гүйцэтгэлтэй байна.

1.2.2 Даатгалын салбар

Тайлант хугацаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас даатгалын үйл ажиллагаатай холбоотой нийт 150 өргөдөл ирснээс хугацаандаа шийдвэрлэгдсэн 142, 8 өргөдөл хуулийн хугацаанд хянагдаж байна.

Хүснэгт 6. Даатгалтай холбоотой өргөдлийн товч утга

Д/д	Өргөдөл, гомдлын товч утга	2017/ IV тоо	Эзлэх хувь	2018/IV тоо	Эзлэх хувь
1	Нөхөн төлбөр олгохоос татгалзсан	101	65.5%	114	76.0%
2	Нөхөн төлбөр олгохгүй удаасан	10	6.5%	14	9.3%
3	Нөхөн төлбөрийг хасч олгосон	24	15.6%	9	6.0%
4	Хохирол үнэлгээний талаар	2	1.3%	3	2.0%
5	Даатгалын хураамжийг илүү тооцсон	4	2.6%	2	1.3%
6	Бусад	13	8.5%	8	5.4%
	Нийт	154	100.0%	150	100.0%

Даатгагчийн зүгээс даатгалын нөхөн төлбөрийг олгохоос татгалзсан гэх өргөдлийн тоог өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулбал 12.9 хувиар өссөн боловч даатгалын компанийн зүгээс нөхөн төлбөр олгохоос үндэслэлтэйгээр татгалзсан тохиолдлын тоо 36.8 хувийг эзэлжээ. Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад, жолоочийн хариуцлагын даатгалын гэрээг байгуулахдаа итгэлцүүрийг буруу хэрэглэснээс даатгалын хураамжийг илүү тооцсон, даатгалын нөхөн төлбөрийг хасч олгосон тохиолдлууд буурсан үзүүлэлттэй байв.

Хүснэгт 7. Даатгалын бүтээгдэхүүний төрөл

Д/д	Даатгалын төрөл	2017/ IV тоо	Эзлэх хувь	2018/IV тоо	Эзлэх хувь
1	Жолоочийн хариуцлагын даатгал	47	30.5%	24	16.0%
2	Авто тээврийн хэрэгслийн даатгал	48	31.2%	65	43.3%
3	Орон сууц, зээлдэгчийн эрсдэлийн даатгал	31	20.1%	22	14.7%
4	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	5	3.2%	7	4.7%
5	Хөрөнгийн даатгал	7	4.5%	5	3.3%
6	Мал амьтны даатгал	2	1.3%	3	2.0%
7	Ачаа, тээврийн даатгал	-	-	4	2.7%
8	Санхүүгийн даатгал	1	0.6%	4	2.7%
9	Зээлийн даатгал	3	1.9%	1	0.7%
10	Хуримтлалын даатгал	2	1.3%	1	0.7%
11	Хариуцлагын даатгал	6	3.9%	4	2.7%
12	Эрүүл мэндийн даатгал	-	-	1	0.7%

13	Агаарын хөлгийн даатгал	-	-	1	0.7%
14	Бусад	2	1.3%	8	5.3%
	Нийт	154	100.0%	150	100.0%

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал жолоочийн хариуцлагын даатгал, орон сууц, зээлдэгчийн эрсдэлийн даатгалтай холбоотой өргөдлийн тоо 48.9, 29.0 хувиар тус тус буурсан бол авто тээврийн хэрэгслийн даатгал болон 35.4 хувиар өсчээ. Тайлант хугацаанд гэнэтийн осол, эмчилгээний болон ачаа, тээврийн даатгалын маргааны тоо өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 8. Даатгалын нөхөн төлбөртэй холбоотой өргөдлийн шийдвэрлэлт

Д/д	Өргөдөл гомдолд хамааралтай даатгалын компани	Нөхөн төлбөр олгохоос татгалзсан нь үндэслэлтэй	Нөхөн төлбөр олгохоос татгалзсан нь үндэслэлгүй	Шүүхэд хандан шийдвэрлэх	Шийдвэрлэх явцад нөхөн төлбөр олгогдсон
1	“Бодь даатгал” ХХК	11	4	1	-
2	“Мандал даатгал” ХК	16	9	4	3
3	“Миг даатгал” ХХК	10	1	1	1
4	“Монгол даатгал” ХХК	3	-	1	-
5	“Номин даатгал” ХХК	1	1	-	-
6	“Соёмбо даатгал” ХХК	3	5	1	1
7	“Ард даатгал” ХК	3	4	1	-
8	“Хаан даатгал” ХХК	2	6	1	1
9	“Практикал даатгал” ХХК	9	3	2	2
10	“Монре даатгал” ХХК	3	2	1	-
11	“Тэнгэр даатгал” ХХК	7	-	3	-
12	“Гэр даатгал” ХХК	1	-	-	-
	Нийт	69	35	16	8

Тайлант хугацаанд Хороонд ирүүлсэн өргөдлийг хуульд заасан хугацаанд урьдчилан шийдвэрлэж, даатгуулагч 29 иргэн, хуулийн этгээдийн нөхөн төлбөрт нийт 622,316,500.00 (Зургаан зуун хорин хоёр сая гурван зуун арван зургаан мянга таван зуу) төгрөгийг олгуулах шийдвэрийг гаргаж, үүнээс нэр бүхий 11 иргэн, хуулийн этгээдэд нийт 133,194,385.00 (Нэг зуун гучин гурван сая нэг зуун ерэн дөрвөн мянга гурван зуун наян тав) төгрөгийн нөхөн төлбөрийг олгуулсан байна.

Хүснэгт 9. Урьдчилан шийдвэрлэгдсэн даатгалын нөхөн төлбөрийн дүн

Д/д	Даатгалын компани	Иргэн, хуулийн этгээд	Шийдвэрлэсэн нөхөн төлбөрийн дүн	Олгогдсон нөхөн төлбөрийн дүн
1	“Ард даатгал” ХК	4	55,910,858	-
2	“Бодь даатгал” ХХК	4	65,878,324	1,220,000 /1/
3	“Соёмбо даатгал” ХХК	5	117,819,113	116,414,913 /3/
4	“Практикал даатгал” ХХК	3	52,368,200	-
5	“Миг даатгал” ХХК	1	6,850,000	6,850,000
6	“Мандал даатгал” ХК	4	66,090,005	456,500 /1/
7	“Номин даатгал” ХХК	1	2,905,200	2,905,200
8	“Хаан даатгал” ХХК	5	250,744,000	2,729,772 /3/

9	“Монре даатгал” ХХК	2	3,750,800	2,618,000 /1/
	Нийт	29	622,316,500	133,194,385 /11/

Дүгнэхэд, Нөхөн төлбөр олгохоос татгалзсантай холбоотой нийт өргөдлийн 30.7 хувийг даатгагч үндэслэлгүйгээр татгалзсан байгаа нь цаашид даатгалын холбогдох хуулиудад нийцүүлэн баталсан журмуудад нарийвчилсан зохицуулалтыг оруулах шаардлага үүссэн нь ажиглагдлаа.

1.2.3 Банк бус санхүүгийн байгууллага

Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдээс банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын үйл ажиллагаатай холбоотой нийт 56 өргөдөл ирснээс 54 нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдэж, 2 өргөдөл хуулийн хугацаандаа хянагдаж байна.

Хүснэгт 10. ББСБ-ийн үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн товч утга

Д/д	Өргөдлийн товч утга	2018/4
1	ББСБ-ын үйлчилгээ	16
2	Зээлийн гэрээний маргаан	14
3	Зээлийн мэдээллийн сангийн бүртгэл	13
4	Бусад (иргэд хоорондын гэрээний маргаан)	13
	Нийт	56

Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор ирүүлсэн өргөдлийн 23.2 хувийг зээлдүүлэгч нь зээлдэгчийн мэдээллийг Зээлийн мэдээллийн санд тухай бүр шинэчлээгүйгээс зээлдэгчийн зээлийн ангилалд сөргөөр нөлөөлсөн нөхцөл байдал үүссэн талаарх өргөдөл байсан ба энэхүү үзүүлэлт өмнөх оноос 6 дахин ихэсчээ.

Иймд Зээлийн мэдээллийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагчид зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяаллыг хамааруулахаар нэмэлт оруулах шаардлагатай байна. Одоогоор Зээлийн мэдээллийн тухай хууль зөрчигдсөн тохиолдолд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.19-д зааснаар зөвхөн Монголбанкны хянан шалгагч зөрчлийн дагуу хянан шийдвэрлэхээр байна.

Дээрх өргөдлүүд дараах байдлаар урьдчилан шийдвэрлэгджээ:

Хүснэгт 11. ББСБ-ийн үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн шийдвэрлэлт

Д/д	Өргөдлийг шийдвэрлэсэн утга	2018/4
1	Холбогдох хариуг өгч шийдвэрлэсэн	29
2	Хууль, хяналтын байгууллагад хандан шийдвэрлүүлэх, харьяаллын дагуу шилжүүлсэн	13
3	Хорооноос үүрэг даалгавар хүргүүлсэн	11
4	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хариуцлага оногдуулсан	1
5	Хуулийн хугацаанд хянагдаж байгаа	2
	Нийт	43

1.2.4 Хадгаламж, зээлийн хоршоо

Тайлант хугацаанд Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)-дын үйл ажиллагаатай холбогдуулан Хороонд нийт 8 өргөдөл ирснийг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэжээ.

Хүснэгт 12. ХЗХ-ны үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн товч утга


Д/д	Өргөдлийн товч утга	2018/4
1	Хадгаламж, зээлийн хоршооны дотод үйл ажиллагаа, хувь нийлүүлсэн хөрөнгийн зарцуулалт, засаглал	6
2	Гэрээний маргаан	2
	Нийт	8

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад, хадгаламж буцаан олгоогүй талаарх өргөдөл шинээр бүртгэгдсэнийг зөрчлийн хэрэг бүртгэлтийг хэрэгжүүлэн шийдвэрлэсэн бол ХЗХ-дын үйлчилгээний чанартай холбоотой өргөдөл бүртгэгдээгүй байна. Өөрөөр хэлбэл, ХЗХ-дын үйлчилгээний чанар тусгай зөвшөөрлийн шаардлагад нийцэж буй, харин тэдгээрийн санхүүгийн зохистой харьцааны хэрэгжилтийг хангуулахад онцгой анхаарал хандуулах шаардлагатай байгаа нь ажиглагдлаа.

2. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ

Тайлант хугацаанд Хяналт шалгалтын газарт нийт 322 өргөдөл, гомдол ирснээс хуулийн хугацаанд шийдвэрлэсэн 310, хянагдах шатандаа байгаа 12 өргөдөл байна.

Дүрслэл 1. Өргөдөл шийдвэрлэх дундаж хугацаа (хоногоор)



Өргөдлийн шийдвэрлэлтийн үйл ажиллагааны процесс, авах арга хэмжээний хүрээ харилцан адилгүй байгаагаас хамааран тухайн өргөдлийн шийдвэрлэх хугацаа өөр өөр байгаа хэдий ч нийт өргөдлийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 22 хоног болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 хоногоор уртассан нь дийлэнх өргөдөл, гомдлын утга, агуулгууд нь тухайн мэргэжлийн нарийвчилсан ур чадвар шаардсан, оролцогч талуудын хоорондын илүү төвөгтэй маргааны хэлбэртэй болсноос гадна зарим зөрчлийн шинжтэй өргөдөлд зөрчлийн хэрэг бүртгэлт хийх, прокурорын байгууллагаар хянуулан шийдвэрлэж байгаатай холбоотой.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР